



## Бурхан бол Дээдийн дээд Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. *Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.*

**Мөн чанар: Бурхан бол Дээдийн дээд**

**Attribute: God Is Supreme**

**Тодорхойлолт:** Хамгаас эрхэм дээд, эрх мэдэлт, хүч чадалт, дээдийн дээд, дээр оршигч Нэгэн.

**Эшлэл(үүд):**

- **Дуулал 95:3-7** ЭЗЭН аугаа Бурхан бөгөөд Бүх бурхдын дээд аугаа Хаан юм. Дэлхийн гүн газрууд Түүний гарт байдаг бөгөөд Уулсын оройнууд ч бас Түүнийх. Далай ч Түүнийх. Учир нь Тэрээр түүнийг бүтээсэн Нэгэн бөгөөд Түүний мутар хуурай газрыг ч хэлбэржүүлсэн. Ирэгтүн, биднийг бүтээгч ЭЗЭНий өмнө мөргөн сөгдөж, сөхөрцгөөе! Учир нь ЭЗЭН, бидний Бурхан бөгөөд Бид Түүний бэлчээрийн ард түмэн, Түүний мутрын хонин сүрэг юм. Өнөөдөр та нар Түүний дууг сонсвол.
- **Исаиа 44:6-8** ЭЗЭН, Израилийн Хаан, түүний Чөлөөлөгч, Түг түмдийн ЭЗЭН ингэж айлдаж байна. “Би эхэн бас Би эцэс. Надаас өөр Бурхан байхгүй. Хэн Над шиг юм бэ? Би эртний хүмүүсийг бий болгосноос хойшхыг Тэр дуудаж, тунхаглаад, Надад дэс дараагаар нь тоочигтун. Айсуй ирээдүйн зүйлсийг ч тэр тэдэнд зарлаг. Бүү түгшигтүн. Бүү мэгд. Би эртнээс чамд үүнийг сонсгож, Тунхагласан биш үү? Та нар гэрчүүд минь юм. Надаас өөр Бурхан байна уу? Өөр Хад байхгүй, Би мэдэхгүй.”
- **Коллосай 1:15-18** Тэр бол үл үзэгдэгч Бурханы дүр бөгөөд бүх бүтээлийн Түрүүнд гарсан нь мөн. Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс, үзэгдэх ба үл үзэгдэх юмс, хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд ч бүтээгдсэн. Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна. Тэр бүх юмсын урьд байна. Бүх юмс Түүгээр оршин тогтнодог. Тэрээр бие болох чуулганы тэргүүн. Тэр бол эхлэл, үхэгсдээс анх төрсөн нь мөн. Энэ нь Тэр Өөрөө бүх юмсын тэргүүн болохын тулд болой.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

*Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.* 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.* 1 Тесалоник 5:18

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

**Өөрсдийн хүүхдүүдийн төлөө** — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

**Эшлэл(үүд):** Иуда 1:24

**Библийн эшлэлээр залбирах:**

Эзэн (Хүүхдийн нэр)-ыг бүдрэхээс хамгаалж, (Хүүхдийн нэр)-ыг Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах билээ.

**Залбирлын тодорхой хүсэлт:**

**Багш/Ажилчид** (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та \_\_\_\_\_-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- Эзэн \_\_\_\_\_-ыг бүдрэхээс хамгаалж, \_\_\_\_\_-ыг Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах билээ. *Иуда 1:24*

**Сургуулийн төлөө залбирах** – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

**Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах** – Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

***Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!***